



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/55

Чингис хот

Байгууллагын ахмадуудад буцалтгүй
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах тухай журам”-ын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ахмадын Сангийн зөвлөлийн 3 дугаар хуралдаанаас гарсан саналыг үндэслэн Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын ахмадуудад нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардлагатай 1,550,000 (нэг сая таван зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгийг байгууллагын ахмадын сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн дарга (Г.Лхагвахатан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030345